

**“Монгол-АНУ-ын Боловсролын
Салбарын Хамтын Ажиллагаанд Олон
Нийтийн Дипломат Ажиллагааны Гүйцэтгэх Үүрэг:
Фулбрайт болон Хамфрейн Тэтгэлэгт
Хөтөлбөрийн жишээн дээр”**

Д.Бүдсүрэн (МА). МУИС-ОУХНУС-ийн ахлах багш

Түлхүүр үг: Олон Нийтийн Дипломат Ажиллагаа, Ардын Дипломат Ажиллагаа, Зөөлөн Хүч, Боловсролын Салбарын Хамтын Ажиллагаа, Соёлын Гадаад Бодлого

Abstract

The article on “The role of Public Diplomacy in the Mongolia-US educational cooperation: In the case of Fulbright Scholarship” covers fundamental ideas of how the public diplomacy affects bilateral relations and cooperation between Mongolia and U.S., known as a soft power and of how some prominent exchanges programs such Fulbright could be influential to the development of reciprocal relations towards our two nations. The significance of this paper goes to the case study of the Fulbrights exchange programs and scholarships in 1994-2015 upon the comparison between U.S. Government funded and Mongolian Government funded ones. The paper has included some potential statistics of former fulbrighters and their research based on interviews, which were provided by the Public Affairs Section at the US Embassy of Ulaanbaatar.

Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш олон улсын харилцаанд олон жил хугацаанд ноёрхсон хүйтэн дайн дуусч, бие биенийгээ сөрөн зогссон хоёр туйлт ертөнцийн бүтэц задарч, олон улсын харилцааны

шинэ тогтолцоо бүрэлдэх үйл явц бэхжиж байна. Хэдийгээр дэлхийн улс гүрнүүд улс төр, нийгэм, эдийн засаг, гадаад худалдаа, тээвэр, аялал жуулчлал, соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбаруудын хөгжлийн шаардлагаар ойртож, харилцан уялдаа холбоогоо бэхжүүлэх нөхцөл бүрэлдэж байгаа боловч улс орнуудын шашин, үндэстэн хоорондын зөрчил нэмэгдэж үндсэрхэг үзэл газар авч, бүс нутгийн хэмжээнд болон тодорхой улс орны дотор зөрчил, мөргөлдөөн гарах магадлал багасахгүй байна. Дэлхийн социалист систем, Зөвлөлт Холбоот Улс задарсан нь түүний холбоотон байсан Монгол Улсын гадаад нөхцөл байдлыг эрс өөрчлөв. Эдүгээ хөрш хоёр оронд гарч буй томоохон өөрчлөлтүүд нь Монгол Улсын гадаад орчин, үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлж байна. Монгол улсын улс төр, нийгэм, эдийн засгийн байгууллын өөрчлөлт, шинэчлэлт улс үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, бодит байдалд тулгуурласан гадаад бодлого түүн дотроо ямар нэгэн аюул дагуулахгүй, хор уршиг үлдээхээргүй, олон нийтийг буюу өргөн цар хүрээг хамарсан, зарим хөрш орнуудад болгоомжлол, хардлага төрүүлэхээргүй, аюул осол багатай түүний зэрэгцээ нэгэн зэрэг гадаад бодлого, үндэсний аюулгүй байдал, дипломат ажиллагааг бүрэн хангаж чадах нөхцөл бололцоог эрэлхийлэх зайлшгүй шаардлагатай тулгарч байна.

Энэ тухайгаа ч Монгол улс анх 1994 онд УИХ-аар баталсан эрх зүйн үндсэн баримт бичиг болох гадаад бодлогын үзэл баримтлалд анх удаа тодорхой дурдсан байдаг. 1994 онд батлагдсан гадаад бодлогын үзэл баримтлалын 5 дугаар зүйлийн 24 дүгээрт зааснаар *“соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны гол зорилго нь монгол туургатны соёл иргэнийг хамгаалах, соёлын өвөрмөц өв уламжлалыг арвижуулж, дэлхийн соёлын нийтлэг ололтоор баяжуулах, түүх соёлын үнэт зүйлсээ сэргээх, хальж гарсан зүйлсийг сурвалжлан олох, шинэ нөхцөлд ажиллах чадвартай боловсон хүчин бэлтгэх зэрэгт соёлын хамтын ажиллагааг чиглүүлэх, улс орноо гадаадад таниулах, улс түмнийг танин мэдэх, тэдэнтэй харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг нэмэгдүүлэхэд оршино”*¹, тус баримт бичгийн 25 дугаарт зааснаар *“Монгол улс соёл, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллахдаа төрийн болон ардын дипломатын аргыг хослуулах,*

1 Гадаад бодлогын үзэл баримтлал, 5.25 зүйл, 1994 он, УБ хот.

хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэх, эрх тэгш харилцан ашигтай байх зарчмыг баримтлана”² гэжээ.

1994 оны гадаад бодлогын үзэл баримтлалын заалтуудаас Монгол улс 1990 оноос олон улсын харилцаанд ямар нэгэн улсын хараа хяналтаас хол бие даасан байдлаар оролцож, шийдвэр гаргах боломжтой болсон тэр үеэс л төрийн болон ардын дипломат ажиллагаа буюу өнөө цагийн хэллэгээр олон нийтийн дипломат ажиллагааны ач холбогдлын чухлыг онцлон тэмдэглэж бусад улс орнуудтай соёл, боловсрол, эрүүл мэнд, спортын салбарт хамтран ажиллах нь Монгол улсын гадаад бодлогын нэн тэргүүний чиглэлд тооцож буйг харуулж байна. Энэ бол ардчилал, хүний эрх, эрх чөлөөг нийгэм, эдийн засаг, улс төрийн байгууллынхаа чиг шугам болгосон орнуудын хувьд нийтлэг хэрэглэдэг дипломат ажиллагааны нэгэн чухал хэлбэр билээ.

МУ-ын Их хурлаас 2011 онд сүүлд шинэчлэн баталсан Гадаад Бодлогын үзэл баримтлалын V дугаар зүйл соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлогын 25 дугаар зүйлд “Соёл, хүмүүнлэгийн салбарын гадаад бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ гээд: 2 дугаарт **“Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад ойртуулан сайжруулах, энэ талаар ахиц дэвшилд хүрсэн улсуудын туршлагыг судалж хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх;**”, 3 дугаарт **“Үндэсний хөгжилд нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг хөгжингүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;**”, 4 дүгээрт **“Боловсрол, соёл, урлаг, спорт, олон нийт, мэдээллийн олон улсын байгууллагатай идэвхтэй харилцах, шаардлагатай гэрээнд нэгдэн орох, ижил төрлийн байгууллагуудын хооронд шууд харилцаа, солилцоо хөгжүүлэх, соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд оролцох, ийм төрлийн арга хэмжээг эх орондоо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх”**³ хэмээн заасан байдаг.

3 дугаар зүйлд “Үндэсний хөгжилд нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг хөгжингүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх,

2 Мөн тэнд.

3 <http://www.mfa.gov.mn/?p=28988>

сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэх заалт нь Монгол улсын хувьд олон улсын нийгэмлэгийн бусад улс орнуудтай ойртон нөхөрлөх, хоёр талын болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг боловсрол, соёл, эрүүл мэнд, урлаг, спортын салбарт хөгжүүлж, “*шинэ нөхцөлд ажиллах чадвартай боловсон хүчин бэлтгэх зэрэгт соёлын хамтын ажиллагааг чиглүүлэх, улс орноо гадаадад таниулах, улс түмнийг танин мэдэх, тэдэнтэй харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг нэмэгдүүлэхэд оршино*” гэсэн 1994 оны гадаад бодлогын үзэл баримтлалын гол зорилгыг бүрэн утгаар нь биелүүлэхэд гол түлхэц болж байна. 1994 болон 2011 оны гадаад бодлогын үзэл баримтлал нь соёл, боловсролын салбарын үйл ажиллагааны гол зорилго, зорилгыг үе үеийн үзэл баримтлалын гол суурь, тэргүүлэх чиглэлд тусгаж өгсөн нь Монгол улс дээр дурдсан салбаруудад, нэн ялангуяа боловсролын салбарт баримтлах гадаад бодлогын жанжин шугам нь өнөөг хүртэл өөрчлөгдөлгүй залгамж, нэгдсэн чанараа хадгалж нэг санаа, нэгдмэл байр суурьтайгаар, шат дараатайгаар хэрэгжүүлэхээр заагдсан нь харагдаж байна.

АНУ, Монгол улсын хооронд байгуулсан түүхэн шинжтэй эрх зүйн баримт бичгүүдийг шүүж үзвэл 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдөр АНУ-Монгол засгийн газрын хооронд байгуулсан хамтарсан мэдэгдлийн 3 дугаар хавсралтад дурдахдаа “АНУ болон Монгол улсын зүгээс хоёр орны иргэд хоорондын харилцааг гүнзгийрүүлэн өргөтгөх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсэн төдийгүй хоёр улс нийгмийн бүтээлч байдлыг бий болгох зорилготой хоёр талын харилцаанд боловсрол, соёлын солилцоо чухал болохыг онцлон тэмдэглэж, хамтын барилдлагыг бэхжүүлэхэд олон нийтийн болон хувийн хэвшлийнхний түншлэл чухал үүрэг гүйцэтгэхийг нотлосон баримт бичиг болж чадсан.”⁴ Энэхүү хамтарсан мэдэгдэл нь Америкийн Нэгдсэн Улс, Монгол Улсын хоорондын өргөжин тэлж буй хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж буйг АНУ-ын Сенатын танхим дэмжиж, уг баримт бичигт дараах байдлаар зааж өгсөн.

Үүнд: *2010 оны нэгдүгээр сард (I) АНУ-ын засгийн газар, Монгол улсын засгийн газар боловсролын солилцооны боломж*

4 Жонатан Эдлтон, “Нэгэн Чухал Хүчин Зүйл: АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа, 1987-2012”, УБ хот, 2012, 171 тал

бололцоог өргөнөөр нэмэгдүүлэхээр тохиролцсон, (2) Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яамны зүгээс АНУ-Монгол улсын **Фулбрайт**ын хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлэхээ амалсан, (3) АНУ-ын Төрийн департаментын зүгээс АНУ-Монгол улсын **Фулбрайт** хөтөлбөрт олгох төсвийн хуваарилалтаа 2010 оны санхүүгийн жилд нэмэгдүүлэхээ мэдэгдүүлэхээр тогтсон.⁵ Мөн тус хамтарсан мэдэгдлийн тавдугаарт, АНУ Засгийн газар Монгол Улстай **боловсрол, соёл болоод ард иргэд хоорондын** одоо буй харилцан солилцоог өргөжүүлэн үргэлжлүүлэх ёстой болно⁶ хэмээн тусгайлан зааж өгснөөс үзэхэд хоёр улсын засгийн боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргасныг харж болно.

Миний бие энэхүү судалгааны ажилдаа Монгол Улс АНУ-ын боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагаа, түүнийг хөгжүүлэхэд үлэмж нөлөө үзүүлж буй АНУ-ын Засгийн Газраас хэрэгжүүлдэг Фулбрайт болон Хамфрейн тэтгэлэгт хөтөлбөрийг судалгааныхаа объект болгон сонгон судалж, өөрийн дүгнэлтийг хийхийг зорьлоо.

1. “Зөөлөн хүч”- Онолын үндэслэл

Олон улсын харилцаанд “зөөлөн хүч” гэдэг ойлголт хэрэглэж эхлээд удаагүй боловч XX зуунаас ч өмнө Их Британи, Франц, Герман зэрэг хүчирхэг эзэнт гүрэн дэлхий даяар нөлөөгөө тогтоохдоо үүний ач холбогдлыг дутуу үнэлж байсан нь үгүй. Олон улсын харилцааг АНУ, ЗХУ гэсэн хоёр хэт их гүрний давамгайлал тодорхойлж байсан өнгөрсөн зууны үед ч “зөөлөн хүч”-ний үүрэг, нөлөө чухал байсан юм. Харин харилцан хамаарал өсч, даяаршлын үйл явц идэвхжиж буй өнөө үед асуудлыг цэргийн хүчээр буюу эдийн засгийн дарамж шахалт үзүүлэх замаар шийдвэрлэх нь ихээхэн өртөгтэй АНУ-ын “зөөлөн хүч”-ийг судлах нь Монгол улсад ямар ач холбогдолтой болох талаар дүгнэж үзнэ.

“Мэдээж зөөлөн хүч гэдэг нь шинэ зүйл огтхон ч биш төдийгүй зөөлөн хүчийг өөртөө бий болгохын тулд өөрийн соёлыг хэрэглээн д оруулахыг хичээсэн анхны засгийн газар АНУ-ынх бас биш. Франц-

5 Жонатан Эдлтон, “Нэгэн Чухал Хүчин Зүйл: АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа, 1987-2012”, УБ хот, 2012, 175 тал

6 Жонатан Эдлтон, “Нэгэн Чухал Хүчин Зүйл: АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа, 1987-2012”, УБ хот, 2012, 176 тал

Пруссын дайнд ялагдсаныхаа дараа Францын засгийн газар 1883 оноос холбоотнуудынхаа дунд өөрийн хэл, соёл, уран зохиолыг түгээн дэлгэрүүлэх замаар үндэстнийхээ шороонд хутгалдсан нэр төрийг сэргээх арга замыг хайж эхэлсэн байдаг. Францын соёлыг хил чанадад сэргээх төслийн ажиллагаа эхэлж, энэ нь Францын дипломат ажиллагааны нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг болов. Энэ нь ч үр дүнгээ өгч, Францын араас Итали, Герман, болон өөр бусад үндэстнүүд ч энэхүү аргыг үг дуугүй хэрэглэсэн юм.”⁷ 1920-иод оноос радиогоор сурталчилгаа явуулах нь олон засгийн газрыг гадаад хэлийг радиогоор нэвтрүүлэх явдалд хөтөлсөн төдийгүй 1930-аад онд Нацист Герман үзэл суртлын шинжтэй киногоо гаргав. Харин Америкийн засгийн газрын хувьд дипломат ажиллагааныхаа зорилгын хүрээнд өөрийн соёлыг ашиглах санаа нилээн сүүлд төрсөн гэж хэлж болно.⁸ Энэ нь Дэлхийн I дайны үед Олон Нийтэд Мэдээллийг Түгээх Зорилготой Хороог байгуулахад хүрсэн бөгөөд сүүлд энх тайван цаг ирснээр тэрхүү хороог татан буулгасан юм. 1930-аад оны сүүлээр АНУ-ын аюулгүй байдал нь дэлхийн бусад улс орнуудын буй ард иргэдэд эерэгээр нөлөөлж тэдний дэмжлэгийг авах чадварт оршино гэдэгт Рузвейлтын засаглалын гол итгэл оршиж байв.⁹ Дэлхийн II дайн, Хүйтэн дайнаас хойш америкийн засгийн газар дээрх бодлогыг илүү үр дүнтэй албан ёсны үйл ажиллагаагаар үргэлжлүүлэх болсоны дотор АНУ-ын Мэдээллийн Агентлаг, Америкийн Дуу Хоолой (VOA), Фулбрайтын Тэтгэлэгт Хөтөлбөр, Америкийн Номын Сан, Лекцүүд болон бусад хөтөлбөрүүд багтаж байна.¹⁰ Зөөлөн хүчний олон хэлбэрүүд засгийн газрын хараа хяналтаас холуур нийгмийн хүчин зүйлээс урган гарч хөгждөг.

Жозеф Най зэрэг улс төр, олон улсын харилцааны онолчид олон нийтийн дипломат ажиллагааны тухай 2004 онд хэвлүүлсэн “Soft Power: Means to Success in World Politics” хэмээх бүтээлдээ сонирхолтой санаа дэвшүүлжээ. Тэрээр улс үндэстнүүд хатуу, аядуу зөөлөн хоёр хүчийг тэнцвэржүүлэн хэрэгжүүлэх боломжтой¹¹ гээд аливаа улс

7 Joseph Nye, “The Paradox of American Power: Why The World’s Only Superpower Can’t Go it Alone”, Oxford Press, NY, 2002, p.69

8 Мөн тэнд. 69 тал

9 Мөн тэнд. 69 тал

10 Мөн тэнд. 70 тал

11 Joseph Nye, Paradox of American Power, Oxford, 2002

гадаад бодлогынхоо хүсэл зорилго, зорилтоо биелүүлэхдээ зөөлөн хүч нь бусад улс үндэстнийг итгэн үнэмшүүлэхэд чиглэдэг бол хатуу хүч, өөрөөр хэлбэл, эдийн засаг, цэрэг зэвсгийн хүчээр бусад улсын эсрэг хориг арга хэмжээ авах, албадах арга хэрэгсэл юм. Энэ хоёр хүчийг зөв хослуулан хэрэглэх боломжтой¹² тухай судлаач бүтээлдээ өгүүлжээ. Зөөлөн хүчний нэг гол хэрэглүүр нь олон нийтийн дипломат ажиллагаа мөн.

2. Ардын буюу Олон Нийтийн Дипломат Ажиллагааны түүх

Дипломат Ажиллагааны үүслийг эртний Месопотами, Грек, Ромын үетэй холбон үздэг бөгөөд энэ үед дипломат ажиллагаа нь заншлын шинж чанартай байв. Мөн түүнчлэн энэ үед дипломат ажиллагаа нь дайн тулааны өмнө илүү боломжит байдлаар тохиролцох найдлага өвөрлөн эсрэг талынхаа өөртэйгөө адил тушаалын хүнтэйгээ уулзахаар армийг тэргүүлэн яваа “элчин сайд” цэргүүдийн жижиг бүлгээс бүрддэг байв. Хэрэв тохиролцож чадвал энх тайван тогтоно, эс чадваас цус урсдаг байв. Ийм маягаар дипломат алба үүсч түүний ач холбогдол нь маргааныг энхийн замаар шийдвэрлэх боломжийг хайхад оршиж байсан юм.¹³

Дэлхий даяар зарлага хийн аялж байсан албан бус “элчин сайд нар” (анхдагчид, байлдан дагуулагчид, зуучлагчид, уран бүтээлчид гэх мэт)-ын зуунууд улиран өнгөрч XX зуунтай золгосноор дэлхийн нийт, элчин сайд нар нь өөрчлөгдсөн төдийгүй арга хэрэгсэл нь ч бас өөрчлөгдсөн нь дипломат ажиллагаа шинээр үүсэн бий болсны гэрч болсон билээ. Дипломат ажиллагаа гэдэг нь өөртөө олон салшгүй хэсгүүдийг багтаан тэр бүр нь өөрийн онцлог шинжийг агуулсаар ирэв.

XX зууны эхний хагаст анхны улсын санхүүжилттэй албан ёсны олон нийтийн дипломат ажиллагаа явуулах байгууллагууд бий болсон нь 1921 онд байгуулагдсан “Германы гадаад албаны соёлын хэлтэс” болоод 1935 онд Их Британид байгуулагдсан байгуулагдсан гадаад оронд тус улсын тухай төсөөллийг сайжруулах зорилготой төлөөлөгч илгээдэг “Британийн зөвлөл” (British Council) зэрэг байв. Америк ч тэднээс нэг их хол хоцорсонгүй. Хүйтэн дайны үед олон нийтийн дипломат ажиллагаа тэр дундаа соёлын дипломат ажиллагааны

¹² Мөн тэнд.

¹³ <http://www.culturaldiplomacy.org/>

арга хэрэгслийг хэрэглэх асуудалд ихээхэн өөрчлөлт хийж, Герман дахь Америкийн ордон (America Hauser) гэх зэрэг байгууллагуудаар дамжуулан “Америкийн түүх”-ийг дэлхий нийтэд ярьж өгч байв.

2.1 Олон Нийтийн Дипломат ажиллагааны тухайд

Олон зуун жилийн турш улс орнуудын гадаад бодлого хүчний бодлого (hard power) дээр тулгуурлан явж ирсэн бол өнөөдөр энэ байдал ихээхэн өөрчлөгдөж аль болох дипломат арга хэрэгслүүдийн тусламжтайгаар, ялангуяа дипломат яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны үндсэн дээр энх тайванч байдлаар асуудлыг шийдэхийг зорих болов. Английн нэрт дипломатч Эрнэст Сатоу “Тусгаар улсуудын засгийн газрууд заримдаа харьяалалд нь байдаг улсуудтай албан ёсны харилцаа холбоо барихад хэрэглэх арга ухаан, эв дүй бүр товчдоо энх тайвны арга хэрэгслээр улс хоорондын харилцааг явуулахыг дипломат ажиллагаа гэнэ”¹⁴ гэжээ.

1. Дипломат ажиллагаа нь түүхийн явцад тус бүртгээ өөр өөрийн онцлог шинж чанар бүхий шинэ шинэ хэлбэр, агуулгаар баяжигдаж ирсэн билээ. Дипломат арга ажиллагааг ерөнхийд нь олон талт ба хоёр талт гэж ангилдаг. Харин гол болон ач холбогдол өгч байгаа арга хэрэглүүрээс нь хамаараад хэд хэдэн хэлбэрт хувааж үзэж болох юм. Жишээ нь: эдийн засгийн арга хэрэгслээр (хөрөнгө оруулалт) дамжуулан гадаад бодлогын хүссэн үр дүндээ хүрэх зорилготой эдийн засгийн дипломат ажиллагаа (economic diplomacy); Засгийн газрууд болон өндөр хэмжээний албан тушаалтнуудаар бус ард иргэдээр дамжуулан улс орнууд харилцахыг чухалчилдаг ардын дипломат ажиллагаа буюу олон нийтийн дипломат ажиллагаа (public diplomacy); улс төр, нийгмийн зүтгэлтнүүдийг ашиглан аливаа зөрчил, маргаантай асуудлуудыг яриа хэлэлцээр шийдвэрлэх, итгэлцэл бий болгох зорилготой хоёр дугаар сувгийн буюу албан бус дипломат ажиллагаа (informal diplomacy or track II); маргаан зөрчилд шууд хамаатай бус гуравдагч тал зуучлагч болж асуудлыг шийдвэрлэхэд оролцдог зуучлалын дипломат ажиллагаа (shuttle diplomacy) зэрэг олон хэлбэрийг нэрлэж болно.¹⁵

¹⁴ Д.Цолмон, Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг, УБ, 2003 он, 25 тал

¹⁵ Мөн гэнд.

Дипломат ажиллагаанд улс орнууд ихээхэн ач холбогдол өгөх болсноор ардын дипломат ажиллагаа хийгээд түүний салшгүй хэсэг болсон соёлын дипломат ажиллагааны үүрэг нөлөө ч нэмэгдэж ирсэн. Тухайлбал, соёлын харилцаанд анхдагч болсон Францчууд гадаад дахь соёлын төлөөллөө ариун үүрэг зорилт гэж үнэлдэг бөгөөд XIV Людовик хааны үеэс Францын гадаад харилцаанд соёлын бодлого чухал байр суурь эзлэх болсон юм.

Соёлын дипломат ажиллагааны чиглэлд гадаад харилцааны төсвийнхөө хагас хувийг зарцуулдаг. (2004 оны байдлаар 42%, 2014 оны байдлаар 40%)¹⁶ Франц улсын хувьд өнөөдөр ч уламжлалаа хадгалан соёлын харилцааг Францын үндэсний эрх ашиг, гадаад бодлоготой адилтган авч үздэг байна. Харин 1945 оноос хойш бусад ардчилсан орнуудын хувьд ерөнхийдөө энэ талын харилцаа нь засгийн газрын удирдлага, хяналтын дор байхаа больсон. Үндэсний хил хязгаараас хальж, бие биетэйгээ харилцах санаа нь сүүлийн 40 гаруй жилд дэлхий нийтийг хамарсан асуудал болоод байгаа бөгөөд энэ нь Европын хамтын нийгэмлэгийн тулгуур үзэл санааны нэг билээ.

Олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг нь илгэлцэл, ойлголцолд хүрэх зорилгоор ард түмэн, янз бүрийн бүлгүүдийн хооронд соёл боловсрол, аялал жуулчлал, хэвлэл мэдээлэл, нийгэм хүмүүнлэгийн үйл ажиллагаагаар дамжуулан мэдээлэл, мэдлэгийг шилжүүлэх арга хэрэгслийг хэлнэ гэж улс төрийн шинжлэх ухаанд тодорхойлсон байдаг.¹⁷ Жишээлбэл Милтон Камминкс (Milton Cummings Jr.) олон нийтийн ялангуяа соёлын дипломат ажиллагаа хэмээх нэр томъёог тодорхойлохдоо хоёр талын ойлголцлыг хөгжүүлэх зорилгоор хамт олны дунд санаа бодол, мэдээлэл, урлаг, амьдралын хэв маяг, үнэт зүйлсийн систем, уламжлал, итгэл үнэмшил хийгээд бусад соёлын зүйлсийг солилцох явдал гэж тодорхойлсон байна.¹⁸ Харин Жозеф Най (Joseph Nye) соёлын дипломат ажиллагааг тодорхойлохдоо “зөөлөн хүч” дээд зэргийн жишээ бөгөөд энэ нь цэрэг, дайны хүчин чадлаар эзлэн албадах “хатуу хүч”-нээс эсрэг зүйлээр буюу соёл, үнэт зүйл, санаа бодлоор дамжуулан ятгах чадвар гэж үзсэн байна.¹⁹

16 Margaret Wyszomirski, Christopher Burgess and Catherine Peila, *International Cultural Relations: A Multi Country Comparison*, 2003

17 http://www.en.wikipedia.org/wiki/Institute_for_Public_Diplomacy

18 Мөн тэнд.

19 *Japanese Diplomatic Bluebook*, 2005, /Topic: Soft Power/, p.p.208

Нэрээр нь хамгийн алдартай тэтгэлэгт хөтөлбөрийг нэрлэсэн Фулбрайт “өнөөгийн ертөнцөд гадаад бодлого нь зөвхөн цэргийн хүч, дипломат ажиллагаанд суурилагаасаа илүү бид үнэт зүйлээ хэрхэн бусдад дамжуулан хүргэж байгаагаас ихээхэн шалтгаалах болсон” гэж 1964 онд бичиж байв.²⁰ “Хоёр улсын хоорондын харилцаа зарим талаараа хувь хүмүүсийн хоорондох харилцаатай төстэй байдаг. Улс төр, эдийн засгийн харилцаанд төвөгтэй байдал үүссэн эсэхээс үл шалтгаалан соёлын харилцаанд ямар нэг хор хохирол учирдаггүй” гэж Францын Ерөнхийлөгч асан Шарль Де Голь хэлдэг байжээ.²¹ Түүнчлэн ХБНГУ-ын канцлер асан Вилли Брандт “олон нийтийн дипломат ажиллагаа, нэн ялангуяа соёлын дипломат ажиллагааг гадаад бодлогын гурав дахь тулгуур” гэж үнэлсэнээс үзэхэд ардын дипломат ажиллагаа буюу олон нийтийн дипломат ажиллагаа нь ямар нэгэн эрсдэл дагуулахгүй, аль нэг хөрш улсын хувьд буруу ойлголт, хардлага сэрдлэг төрүүлэхээргүй, зөөлөн аргаар хүч үл хэрэглэн ард түмнүүдийн хооронд зөвхөн “итгэлцлийг бий болгох”, “хамтын ажиллагааг” өргөжүүлэх зорилготой үр дүнтэй дипломат ажиллагааны нэгэн төрөл хэмээн тодорхойлж болохоор байна.

Дээр дурдсан зүйлүүдийг нэгтгэн үзэхэд олон нийтийн дипломат ажиллагаа нь:²²

- Улс төр, эдийн засаг, цэргийн хэлэлцээрт хүрэхийг зорьж буй бодлого боловсруулагчдад бусад ард түмнүүдтэй “илтгэлцэл бий болгох”-д нь тусалдаг.
- Нийтлэг ашиг сонирхол байгаа тохиолдолд бол нэг улсын явуулж буй тодорхой бодлогын асуудал буюу хамтран ажиллах хүсэлтэнд нөгөө улс нааштай хариу өгөх орчинг бий болгох.
- Тухайн орны үнэт зүйл, ашиг сонирхлын тухай бусад улс орнуудад ойлгуулж тэдгээр улсуудын олон нийтийн дунд бий болсон тухайн улсын талаарх буруу бодол, төсөөллийг өөрчлөх боломжийг олгодог.
- Уламжлалт элчин сайдын яамдын үүргийн тусламжтайгаар хүрэх боломжгүй гадаа орнуудын нийгмийн нөлөө бүхий гишүүдэд хүрч

20 Dr. Robert Taylor, The British Council, Cultural Diplomacy-The Future

21 http://www.azer.com/aiweb/categories/magazine/84_folder/84_articles/84_guinhut.html

22 Committee on Cultural Diplomacy in U.S. Department of State, “The Cultural Diplomacy is linchpin of Public Diplomacy” report, Sep 2005

- ажиллах боломжийг олгоно.
- Бодлогын зөрүүтэй байдлыг үл харгалзан хамтын ажиллагааг бий болгох эерэг орчноор хангаж өгнө.
 - Хүн хүнтэйгээ харилцах дундын орон зайг бий болгодог.
 - Дипломат харилцаа тогтоогүй эсвэл дипломат харилцаа тасарсан орнуудтай нөхөрсөг харилцаа бий болгоход чиглэсэн уян хатан, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэрэгсэл болдог.
 - Иргэний нийгмийн хөгжлийг дэмждэг.
 - Улс орнуудын нийгэм дэх бусдын үнэт зүйлд мэдрэмхий ханддаг чанарыг ойлгох боломжийг өгдөг.
 - Үл ойлголцол, өс хонзон, терроризм зэрэг асуудлын эерэг сөрөг тэнцвэрийг бий болгоно.
 - Нээлттэй байдал, тэвчээртэй байдлын талаар гадаад, дотоод хэлэлцүүлгийг хөгжүүлж чаддаг гэх мэт ач холбогдолтой юм. Үүнээс үзэхэд олон нийтийн буюу ардын дипломат ажиллагаа нь аливаа улсын гадаад бодлогыг энхийн замаар хэрэгжүүлэх арга хэрэгслийн нэг хэлбэр мөн билээ.

Язгууртан угсаатны явцуу хүрээнд төр, засгийн газрын түвшинд нууцлаг шинж чанар нь давамгайлж байсан уламжлалт дипломат ажиллагаа эдүгээ өөрчлөгдөн шинэчлэгдэж, ил тод, олон туйлт үзэл бодлыг эрхэмлэсэн, илүү чөлөөтэй, бүх нийтийг хамрах чиг хандлагатай боллоо. Ийнхүү уламжлалт дипломат ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн тэлэх, нийгмийн доторх ашиг сонирхлын бүлэглэлүүд, олон нийтийн байгууллагууд, бусад байгууллауудын үзэл баримтлал, үүрэг, нөлөөг дээшлүүлэх зорилго бүхий олон нийтийн буюу ардын дипломат ажиллагааны арга хэлбэрийг орчин үеийн олон улсын харилцаанд ихээхэн анхаарч судалж байна.²³

Олон нийтийн дипломат ажиллагааны нэг гол чиглэл нь олон улсын амьдрал, түүнд оролцох Засгийн газрын албан ёсны байр суурь ямар байгааг олон түмэн мэдэж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөхийн сацуу гадаад ертөнцөд явуулж буй төр, засгийн гадаад бодлогыг боловсрулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог ашиглах, нээлттэй, ардчилсан шинж чанартай түгээмэл үзэгдэл юм.²⁴ Олон нийтийн дипломат

23 Д.Цолмон, Д.Оюунсүрэн, С.Баясгалан. “Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс”, УБ, 2009 он, 40 тал.

24 Мөн тэнд.

ажиллагааны хамгийн гол ач холбогдол нь үндэсний аюулгүй байдлын нөхцлийг тодорхой, өргөн хүрээтэй, зохистой аргаар нэмэгдүүлж улмаар зөөлөн хүчийг ашиглан олон улсын харилцааг удирдах, гэрээ хэлэлцээ хийх, холбоо байгуулах, бодлого боловсруулах зэрэг боломжуудыг засгийн газруудад олгодог оршино.

АНУ-д ерөнхийлөгч Вудро Вилсоны засаглалын үед олон нийтийн мэдээллийн хороо байгуулж Америкийн ард түмний соёлын үнэт зүйлс, ардчилалын мөн чанарын тухай, мөн дэлхий дахинд болж буй томоохон үйл явдлуудын талаар Америкийн байр суурь, үнэлэлтийг илэрхийлдэг “Америкийн дуу хоолой” радио станцийн нэвтрүүлэг, Английн “Би Би Си”-гийн дараа орохуйц хүчтэй хэрэгсэл болж чаджээ. Дэлхийн олон хэлээр явуулдаг энэ нэвтрүүлэг 1942 оноос эхлээд нацист Германы эсрэг сөрөг суртал нэвтрүүлэг хийж байснаа 2-р дайны дараа Зөвлөлтийн эсрэг хүчтэй суртал ухуулга хийж дэлхийн олон нийтийн сэтгэл санаанд нөлөөлөхөөс гадна үнэн бодит байдлыг ойлгуулан сэнхрүүлэх зорилгоор гадаад улсуудын үндэсний хэлээр нь нэвтрүүлэг явуулж гадаад сурталчилгаа өргөжив.²⁵

Олон нийтийн дипломат ажиллагаа нь огт шинэ үзэгдэл бус, түүний элементүүд 20-р зууны дунд үеэс нилээн идэвхижсэн гэж үздэг. Ерөнхийлөгч Дувайт Эйзенхаур энх тайвныг сахин хамгаалахад мэдээлэл, боловсрол чухал хүчин зүйлс болохыг дурьдаж, ерөнхийлөгч Кеннеди хөгжиж буй улс орнуудад тайван хувьсгал хийж, Америкийн хэл соёлыг түгээн дэлгэрүүлж, улмаар хүмүүсийн хүмүүсийн харилцан ойлголцлыг бэхжүүлэх зорилгоор 1961 оноос 10 гаруй мянган америк залууг дэлхийн янз бүрийн улсуудад илгээж байв. Энэ нь дэлхийн хөгжиж буй 40 гаруй оронд мэргэжилтэн залуусыг илгээдэг Энх тайвны корпус юм. ХХ дугаар зууны хоёрдугаар хагасаас дэлхий дахины хэрэг явдалд олон нийтийн оролцоо эрс нэмэгдэв. Ерөнхийлөгч Кеннедийн үед АНУ-ын Мэдээллийн агентлагын захирал байсан Эдвард Мурроугийн тодорхойлсноор “... олон нийтийн дипломат ажиллагааны үндсэн зорилго нь бусад гадаад улс орнуудын удирдагчдад АНУ-ын гадаад бодлогыг эерэгээр ойлгуулах, улмаар ард түмэнд нь зөв сэтгэгдэл төрүүлэх, нааштай уур амьсгал буй болгоход чиглэнэ гэжээ.”

25 Мөн тэнд.

АНУ-ын Тафтын Их сургуулийн эрх зүй, олон улсын харилцааны Флетчерийн сургуулийн захирал асан Эдмунд Гульон 1965 онд ардын буюу олон нийтийн дипломат ажиллагааны (public diplomacy) тухай гадаад бодлогыг бүрэлдүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд олон нийтийн санаа бодлоор нөлөөлдөг уламжлалт дипломат ажиллагааны араас олон улсын харилцааг өргөжүүлэх, бусад улс орнуудын Засгийн газраар дамжуулан гадаад бодлогоо ард түмэн, олон нийтэд хүргэх, хувийн секторын янз бүрийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын бүлэг, нөгөө талын ижил төстэй байгууллага хэсэгт олон улсын хэрэг явдлын талаар мэдээлж, нөлөөлж соёл мэдээллийн төрөл бүрийн хэлхээ холбоог бэхжүүлдэг тухай²⁶ тэмдэглэжээ.

АНУ-ын Төрийн Департамент Мэдээллийн Агентлагийг 1999 онд нэгтгэснээр олон нийттэй харилцах, хүмүүнлэгийн дипломат ажиллагаа үндсэндээ хумигдсан гэж зарим судлаач үздэг тал бий. Эдүгээ Төрийн Департаментын Хүмүүнлэг болон Олон Нийттэй харилцах асуудал эрхэлсэн туслах нарийн бичгийн даргын удирдлагад 40 гаруй хүнтэй алба, гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад тусгай алба ажиллаж байна. Ихэнх улсын гадаад албанд олон нийттэй харилцах аппарат, соёл хүмүүнлэгийн ажлыг уялдуулдаг бие даасан хэлтсүүд ажилладаг. Америкийн Төрийн Департамент дахь олон нийтийн дипломат ажиллагааны үйл ажиллагаа нь АНУ-ын үндэсний ашиг сонирхлыг гадаад ертөнцөд таниулж, түүний тухай үнэн зөв мэдээлэл өгч гадаад бодлогод эерэгээр нөлөөлдөг. Хамгийн гол зорилго нь гадаад улс үндэснүүдтэй харилцан зөв ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэхэд оршино.

ИБУИНВУ-д Британийн зөвлөл гадаад харилцааны албатай хамтарч Английн соёл хүмүүнлэгийн болон олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлдэг байна. ОХУ, ХБНГУ, Япон, БНСУ аль аль нь хүмүүнлэг, соёлын харилцаа олон нийтийн дипломат ажиллагаанд сүүлийн үед ихээхэн анхаарч хэл, соёлоо сурталчлан, хүн солилцоо, аялал жуулчлалыг өргөжүүлж байна. Энэ чиглэлийн институт, төрийн бус байгууллагууд бусад орнуудтай болон тэдгээрийн холбогдох байгууллагуудтай яриа хэлэлцээ явуулж, үндэсний ашиг сонирхлоо хамгаалахын зэрэгцээ улс үндэстнээ тэдэнд ойлгуулж, мэдээлж нөлөөлөх явдал юм.

26 Edmund Gullion, What is a public diplomacy, Washington, 2002

Үүнд:

- Гадаад улс үндэстнүүдийн соёл, ёс ёслол, зан заншилд тохируулан гадаад бодлогыг тайлбарлах, таниулах;
- АНУ болон Америкийн ард түмэн, үнэт зүйлс, байгууллагуудын тухай мэдээлэл хийх;
- Судлаач, оюутан, сэтгүүлч зэрэг хүн солилцоо, удаан хугацааны хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;
- Америкийн гадаад бодлогын шийдвэр гаргагчид гадаад бодлогын талаарх хандлага, тэдгээрийн биелэлтэд санал зөвлөмж дэвшүүлэх зэрэг болно.

Олон нийтийн дипломат ажиллагаа нь уламжлалт дипломат ажиллагаатай харьцуулвал зөвхөн Засгийн газар хооронд бус, төрийн бус олон нийтийн бие даасан байгууллагуудаар хэрэгждэг. Мөн түүнчлэн олон нийтийн дипломат ажиллагаа нь Америкийн засгийн газрын үзэл бодолд бие даасан, хувийн салбар, байгууллагуудаар дамжуулан нөлөөлдөг талтай. Харин уламжлалт ажиллагааны хувьд нэг Засгийн газар нь нөгөөтэйгөө харилцахдаа гадаадад суугаа элчин сайдын яамдуудаар дамжуулж Засгийн газрынхаа бодлогыг голдуу тухайн улсын Засгийн газарт ойлгуулж, хэрэгжүүлдэг бол олон нийтийн дипломат ажиллагааны хувьд тухайн улсад байгаа нийгмийн олон янзын давхарга, төрийн бус байгууллагуудаар дамжин үйл ажиллагааны зорилт хэрэгждэг байна.

Хүйтэн дайны дараа хоёр ертөнцийн нэг талаас нөгөөд хандсан сурталчилгаа өөрчлөгдөж, олон талтай болж, хамрах хүрээ нь өргөжсөн ажээ. Олон улсын байдалтай уялдан энэ чиглэлийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрт нэгэн адил ихээхэн өөрчлөлт гарчээ. Жишээ дурдахад олон нийтийн дипломат ажиллагаанд мэдээлэл холбооны технологи, ялангуяа интернэт сүлжээ мэдээллийг дамжуулах чухал хэрэгслийн үүрэг гүйцэтгэх болов.

Олон нийтийн дипломат ажиллагааны элементүүдийн дотор:

1. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, тэдгээрийн олон хэлбэр
2. Боловсрол, соёлын сурталчилгаа, солилцооны хөтөлбөрүүд
3. Хүмүүнлэгийн үйл ажиллагаа, олон улсын тусламжийн хөтөлбөрүүд

4. ШУТ-ийн хөтөлбөр, судлаач эрдэмтдийн солилцоо
5. Төрийн бус байгууллагууд, Холбоод, Сангуудын хамтын ажиллагаа, сайн дурын хөтөлбөрүүд
6. Аялал жуулчлал буюу хувийн салбарын харилцаа холбоо зэрэг олон хэлбэрүүдийг нэрлэж болно.

АНУ-ын Төрийн Департамент нь Америк болон Монгол улсын хооронд ард түмэн, иргэдийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилгоор соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарт олон төрлийн солилцооны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. АНУ-ын Төрийн Департаментын Боловсрол, Соёлын Харилцааг зохицуулах Төв Товчоо нь боловсрол, соёл, иргэд, төгсөгчид, болон соёлын өвийг хадгалан солилцох үйл ажиллагаагаа зэргийг хэрэгжүүлж АНУ болон Монгол улсын хооронд дипломат болон түншлэлийн харилцааг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.²⁷ АНУ-ын Төрийн Департамент АНУ, Монгол улсын ард түмний хоорондын харилцаа хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг хөхүүлэн дэмжих зорилготой олон төрлийн солилцооны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. АНУ-ын Төрийн Департаментын Соёл, Боловсролын Харилцаа Хариуцсан Товчоо болон Монгол улсын хоорондын түншлэлийн хүрээнд хоёр орны соёл, боловсрол, иргэд, төгсөгчид болон соёлыг хайрлан хамгаалах солилцооны хөтөлбөрүүдийн тусламжтайгаар дипломат харилцаагаа өргөжүүлж байна.²⁸

АНУ-ын Элчин Сайдын Яамны Олон Нийттэй Харилцах Хэлтэс нь боловсрол, соёлын солилцоо, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа хариуцан ажиллахаас гадна элчин сайдын яамны вэб хуудсыг хөтлөн явуулдаг. Мөн түүнчлэн тус хэлтэс нь Фулбрайтын Гадаад Оюутны хөтөлбөр, Фулбрайтын Шинжлэх Ухаан, Технологийн Шагнал, Фулбрайтын Гадаад Хэлний Багшийн Туслах, Хампрейн Тэтгэлэг, Бакалаврын зэргээр Суралцагч Оюутнуудын Хөтөлбөр зэрэг АНУ-ын Засгийн газраас хэрэгжүүлдэг олон төрлийн солилцооны хөтөлбөрийг хариуцан ажилладаг. Үүнээс гадна АНУ-ийн сургалт, судалгааны мэргэжлийн институтад зарим нэг тодорхой чиглэлээр очиж суралцахын хажуугаар судалгаа хийх богино хугацааны хөтөлбөр

27 Media Note of Office of the Spokesperson, U.S. Department of State Public Diplomacy Programs for Mongolia, Washington DC, June 17, 2011

28 Media Note of Office of the Spokesperson, U.S. Department of State Public Diplomacy Programs for Mongolia, Washington DC, June 17, 2011

болох Олон Улсын Зочин Судлаачын Манлайлыг Дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тус хэлтэс нь олон нийтийн мэдээллийн төвийн үйл ажиллагааг эрхлэх бөгөөд АНУ-д мэргэжил дээшлүүлэх сонирхолтой хэн бүхэн ялангуяа Монголын засгийн газрын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн сэтгүүлчдийн сургалт, судалгааг дэмжих тал дээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг. Улаанбаатар хотын номын сан, (хуучнаар Нацагдоржийн номын сан) болон Ховд аймагт байрлах Америкийн Соёл, Мэдээллийн хоёр ч төвийн үйл ажиллагааг санхүүгийн хувьд дэмжин ажилладаг. Дээр дурдсан соёл, мэдээллийн төвүүд нь олон нийтэд нээлттэй бас үнэ төлбөргүйгээр үйлчилдэгээрээ онцлог төдийгүй ард иргэд, залуучуудад өөрсдийн ур чадвараа дээшлүүлэх, Америкийн үнэт зүйлсийг ойлгоход тусалдаг. Соёлыг хайрлан хамгаалах, Эмэгтэйчүүдийн асуудлыг Санхүүжүүлэх, Ардчилалыг Хөхүүлэх Дэмжих, Багахан Хэмжээний тэтгэлэг зэрэг олон төрлийн тэтгэлэгийг олгодог. АНУ-ын ЭСЯ-наас Монголын англи хэлийг сонгон суралцагчдыг урам зоригийг дэмжих үүднээс Англи Хэл Суралцагчийн Хөтөлбөр, Аксес Микро Тэтгэлэгийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ англи хэлний сургалтын хөтөлбөрүүд болох олон арван сургалт, бага хурлуудыг зохион байгуулдаг.

АНУ-ын элчин сайдын яамны Соёл, Боловсролын Харилцаа Хариуцсан Товчоо болон Олон Нийттэй Харилцах Албанаас Монгол улсад хэрэгжүүлж Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөр нь анх 1994 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар нийтдээ 120 гаруй Монголын оюутан, судлаачдыг боловсролын солилцооны хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлсэн байна. 2010 оны нэгдүгээр сард БСШУ-ны сайд Ё. Отгонбаяр болон АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жудит Мкэйл нар Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлэх Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилт болон АНУ-ын засгийн газраас хэрэгжүүлэх Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт үзүүлэх хөрөнгийн нэмэгдсэн санг баталгаажуулан хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан билээ. Тус оны 12 дугаар сараас эхлэн Монгол улсын засгийн газар 2011 оны намрын улиралд АНУ-д очиж ахисан түвшинд буюу магистрын зэргээр суралцах анхны оюутнуудыг илгээхээр болсон юм.²⁹

29 Мөн тэнд.

1. Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөр

АНУ-ын элчин сайдын яамны Соёл, Боловсролын Харилцаа Хариуцсан Товчоо болон Олон Нийттэй Харилцах Албанаас Монгол улсад хэрэгжүүлж Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөр нь анх 1993 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар нийтдээ 20 гаруй Америк, Монголын оюутан, судлаачдыг боловсролын солилцооны хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэн ажилладаг. 2010 оны нэгдүгээр сард БСШУ-ны сайд Ё. Отгонбаяр болон АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жудит Мкэйл нар Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлэх Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилт болон АНУ-ын засгийн газраас хэрэгжүүлэх Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт үзүүлэх хөрөнгийн нэмэгдсэн санг баталгаажуулан хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан билээ. Тус оны 12 дугаар сараас эхлэн Монгол улсын засгийн газар 2011 оны намрын улиралд АНУ-д очиж ахисан түвшинд буюу магистрын зэргээр суралцах анхны оюутнуудыг илгээхээр болсон юм. Одоогийн байдлаар энэхүү өрсөлдөөнт хөтөлбөрийн хүрээнд Монголын шилдэг 4 оюутан АНУ-д докторын зэргээр элсэн суралцаж төгссөн байна.

“Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 71 дүгээр чуулганы 2016 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн Бүгд хуралдаанаар Монгол Улсаас санаачилсан “Ардчиллын боловсролын тухай” тогтоол нийтийн зөвшилцлөөр батлагдав. *Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч С.Сүхболд тогтоолыг танилцуулж хэлсэн үгийнхээ эхэнд боловсрол бол даян дэлхийн энх тайван, сайн сайхан, тогтвортой хөгжлийн гол суурь тул Ардчиллын боловсролын тухай тогтоолд ардчилсан засаглал, энх тайван, хөгжил болон хүний эрх, эрх чөлөөг хөхүүлэн дэмжих асуудлын уялдаа холбоог дахин нотолсон гэж тэмдэглэв.* Мөн тогтоолд гишүүн орнуудын үндэсний, бүс нутаг, олон улсын боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрт ардчиллын боловсролын асуудлыг иргэний, хүний эрхийн, тогтвортой хөгжлийн боловсролын хамт тусгаж, ардчиллын үнэт зүйлийг дэмжсэн бүх түвшний хөтөлбөрийг бэхжүүлэх, туршлага солилцохыг уриалахын зэрэгцээ энэ үйлсэд олон улс, НҮБ-ын холбогдох байгууллагууд, судлаачид, иргэний нийгэм, сан зэрэг бүх талын оролцоо, дэмжлэг хэрэгтэйг дурдсан шинэлэг заалтууд орсныг тэрбээр цохон тэмдэглэв.

Уг тогтоолд Австри, Аргентин, АНУ, Бельги, Герман, Гүрж, Канад, Коста Рика, Испани, Итали, Латви, Люксембург, Мексик, Молдова, Монако, Монтенегро, Морокко, Перу, Польш, Румын, Словак, БНСУ, Парагвай, Турк, Хорват, Унгар, Филиппин, Финлянд, Франц, Чех, Швед, Эстони, Энэтхэг, Япон зэрэг төрөл бүрийн бүс нутгийн төлөөлөл дөч гаруй орон хамтран зохиогчоор нэгдсэн нь ардчиллын боловсролын асуудлыг гишүүн орнууд өргөнөөр дэмжиж байгааг харуулав.”³⁰

Хамфрейн тэтгэлэгт хөтөлбөр

АНУ-ын засгийн газар, АНУ-ын элчин сайдын яамны Соёл, Боловсролын Харилцаа Хариуцсан Товчоо болон Олон Нийттэй Харилцах Албанаас Монгол улсад хэрэгжүүлж Хамфрийн тэтгэлэгт хөтөлбөр нь анх 1996 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар нийтдээ 35 гаруй дундаж насны Монголын судлаач, мэргэжилтнүүдийг уг олон улсын боловсролын солилцооны хөтөлбөрт хамруулаад байна.

Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх бичил судалгаа

Монгол Улсын засгийн газраас 2011 онд шинэчлэн баталсан Гадаад Бодлогын үзэл баримтлалын 25.3 дугаар зүйлд **“Үндэсний хөгжилд нэн шаардлагатай мэргэжилтнүүдийг хөгжсүнгүй улсуудад бэлтгэх, гадаадын өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх** гэх заалт нь *Монгол улсын хувьд олон улсын нийгэмлэгийн бусад улс орнуудтай ойртон нөхөрлөх, хоёр талын болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг боловсрол, соёл, эрүүл мэнд, урлаг, спортын салбарт хөгжүүлж, “шинэ нөхцөлд ажиллах чадвартай боловсон хүчин бэлтгэх зэрэгт соёлын хамтын ажиллагааг чиглүүлэх, улс орноо гадаадад таниулах, улс түмнийг танин мэдэх, тэдэнтэй харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг нэмэгдүүлэхэд оршино”* гэсэн заалт нь 1994 оны гадаад бодлогын үзэл баримтлалын гол зорилгыг бүрэн утгаар нь биелүүлэхэд гол түлхэц болж байна.

АНУ, Монгол улсын хооронд соёл, боловсролын салбарт хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх тэр дундаа АНУ-д Монгол улсын үндэсний хөгжилд нэн шаардлагатай боловсон хүчин,

30 http://www.mfa.gov.mn/?page_id=18063

мэргэжилтнүүдийг бэлтгэх, АНУ-ын их дээд сургуулиудаас өндөр мэргэшлийн багш, эрдэмтдийг ирүүлж ажиллуулах нөхцөл бүрдүүлэх, сургууль, судалгааны байгууллага байгуулах зэрэг тус улсаас боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зүй ёсны шаардлага урган гарч байна. Энэхүү зорилгыг биелүүлэхэд АНУ-ын засгийн газраас хэрэгжүүлж буй Фулбрайт, Хамфрийн тэтгэлэгт хөтөлбөрийн үүрэг өндөр ач холбогдолтой юм.

Аливаа хоёр орны харилцаа иргэд хоорондын харилцаан дээр суурилах аваас “энэ нь улс орнуудын хамтын нөхөрлөлийн гол хүчин зүйл төдийгүй бусад чиглэлийн урт удаан хугацааны харилцааг бий болгох үндэс суурь болдог”³¹ хэмээн 2009-2012 онд АНУ-аас Монгол улсад Онц Бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд ноён Жонатан Эдлтон өөрийн бүтээлдээ дурдсан байдаг. Монгол, АНУ-ын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтохоос бүр өмнө америк, монгол хүмүүс хоорондоо уулзаж, санаандгүй байдлаар учирч байв. 1920-оод онд Монголын их говиор аялсан Рой Чапмен Эндрюсын шинжилгээний ангийн аялалын үеэр авсан гэрэл зургууд харилцааны эхэн үеийн зарим түүхийг мөн гэрчилнэ.³²

Хоёр орны ард түмэн хоорондын өнө удаан жилийн нөхөрсөг харилцааг бий болгоход зөөлөн хүчний гол үүрэг оршино. Өмнө дурдсанчилан, энэхүү хүчийг хэрэгжүүлэхэд боловсрол, соёлын солилцоо болон урт, богино хугацааны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрүүд гол суурь болохоос гадна энэ нь өөрийн улсын талаарх эерэг имидж, төсөөллийг нөгөө улс үндэстэнд бий болгож, ард түмэн хоорондын урт удаан хугацааны нөхөрсөг харилцаа, бүрэн ойлголцлийн үндсийг тавьдаг байна.

1990 онд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагын (USAID) тэтгэлгээр анхны 4 монгол оюутан АНУ-д суралцахаар ирснээс хойш Монгол, АНУ-ын боловсролын салбарын хамтын ажиллагаа жилээс жилд өрнүүн хөгжиж иржээ. АНУ-д суралцах монгол оюутны тоо жил бүр өсч, олон зуун монголчууд жил бүр өөрсдийн хөрөнгө зардлаар, зарим нь хувийн тэтгэлэг хүртэх замаар, өөр нэг хэсэг нь засгийн газрын олон төрлийн тэтгэлэгт хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр АНУ-ын

31 Жонатан Эдлтон, “Нэгэн Чухал Хүчин Зүйл: АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа, 1987-2012”, УБ хот, 2012, 125 тал

32 мөн тэнд.

их дээд сургууль, коллежид суралцах болсон.³³

1946 онд АНУ-ын Сенатораар ажиллаж байсан Уиллям Фулбрайтын нэрээр нэрлэгдсэн, олон улсын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилготой Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрийг АНУ-ын Засгийн газар Улаанбаатар дахь АНУ-ын ЭСЯ-ны Олон нийттэй харилцах албанаас Монголд анх 1994 оноос хэрэгжүүлж эхэлснээс хойш энэхүү хөтөлбөр АНУ-ын Засгийн газрын Фулбрайтын нийт 4 тэтгэлэгт хөтөлбөрийн дотроос хамгийн өрсөлдөөнтэй, үр өгөөжтэй, нэр хүндтэй, Монгол улсын боловсрол, нийгмийн салбарын хөгжилд өнөөг хүртэл тасралтгүй 23 жилийн туршид ахисан түвшний чанартай боловсролыг нас, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, нийгмийн гарал үүсэл, нийгэмд эзлэх байр суурийг үл харгалзан олгодог хөтөлбөр гэдэгтэй маргах хүн үгүй бизээ. Энэ нь оюутан, судлаачид, багш, мэргэжилтнүүд, шинжлэх ухааны салбарын эрдэмтэд, урлагын салбарынханд зориулсан зөвхөн өргөдөл гаргагчийн хувийн онцлог, чадварт үндэслэн зэргийн болон зэргийн бус боловсрол олгодог олон улсын солилцооны хөтөлбөр мөн. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь АНУ-ын ард түмэн болон бусад улс орны иргэдийн хоорондын харилцааг дэмжиж хөгжүүлэх юм.³⁴ 1994 оноос албан ёсоор хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн энэ хөтөлбөрт хамрагдсан хүмүүс сурах, багшлах, судалгаа хийх боломжоор хангагдана. Фулбрайтын дөрвөн төрлийн тэтгэлгээс оюутан залуусын хамгийн их сонирхдог нь магистрт суралцах боломж олгодог Фулбрайт гадаад оюутны хөтөлбөр (Fulbright Foreign Student Fellowship) юм.

2011 оны эхээр Монгол улсын засгийн газраас Фулбрайтын санд 300.000 ам доллар бүхий санхүүгийн анхны хувь нэмрээ үзүүлсэн бөгөөд сургалтын тэтгэлэгийн боломж, нөөц бололцоог өргөжүүлэх, магистрын зэрэг горилогчдын тоог нэмэгдүүлэх зорилготойгоор жилд дунджаар 15 хүртэлх хүнийг АНУ болон Монголын засгийн газраас олгодог тэтгэлэгт хөтөлбөрт хамруулж эхэлсэн юм. Фулбрайтын тэтгэлэг хүртсэн суралцагчдын мэргэжил, дадлага, суралцах газрын хувьд өргөн цар хүрээг хамрах бөгөөд мэргэжлийн чиглэлийн хувьд олон улсын харилцаа, нийтийн удирдлага, эдийн засаг, нийтийн эрүүл


³³ Жонатан Эдлтон, “Нэгэн Чухал Хүчин Зүйл: АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа, 1987-2012”, УБ хот, 2012, 126 тал

³⁴ Б.Хонгорзул “Гадаадад Магистрт Суралцах Арга Зам”, МУИС Пресс, УБ, 2016 он, 23 тал


мэнд, биологи, хот төлөвлөлт, мэдээллийн технологи, эрчим хүч, сэтгэл судлал, сэтгүүл зүй, боловсрол, хууль зүй, геологи, уул уурхай, улс төр, бизнесийн удирдлага, нийгмийн ажил, экологи, хүрээлэн буй орчны асуудлууд, америк судлал, соёл урлаг, антропологи, дуу хөгжим зэрэг олон салбаруудад зэргийн болон зэргийн сургалтыг дүүргэж магистрын зэргийг горилоод байна.

2016 оны 12 сарын байдлаар 1994 оноос хойш өнөөг хүртэл Фулбрайтын урт болон дунд хугацааны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан нийт 140 хүн байгаагийн 78 нь буюу 55% нь 1993 оноос АНУ-ын засгийн газраас МУ-д хэрэгжүүлж эхэлсэн Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт; 62 хүн буюу 45% нь 2011 оноос Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн хөтөлбөрт тус тус хамрагдаад байна. Үүнээс одоогийн байдлаар 4 хүн зэргийн бус сургалтанд 1 жилийн хугацаатайгаар, 5 хүн докторын зэрэг хамгаалахаар Фулбрайтын тэтгэлэгийг хүртсэн бөгөөд боловсролын удирдлага (1998-2001), ойн экологи, түүний менежмент (2008-2011), экологи (2009-2012), экологи (2010-2013), эдийн засаг (2012-2014) чиглэлээр тус тус 2-3 жилийн хугацаанд суралцаж төгссөн байна.

Хүснэгт.1 1994-2016 онд Фулбрайтын хөтөлбөрт хамрагдагсадын статистик тоо



Хүснэгт.2 1994-2016 онд Фулбрайтын хөтөлбөрт аль засгийн газрын хамрагдсан талаарх статистик тоон үзүүлэлт.



Магистрын зэрэг горилсон хүмүүсийн тоо 2016 оны 12 сарын байдлаар 131 байгаагаас АНУ-ын засгийн газраас олгодог тэтгэлгээр 69 хүн 1997-2016 онд тус бүр 1-2 жилийн хугацаанд, Монголын засгийн газраас олгодог Фулбрайтын сангийн тэтгэлэгээр 62 хүн 2011-2016 онд тус бүр 2 жилийн хугацаанд зэргийн сургалтанд хамрагдаад байна. Магистрын зэрэг горилон суралцагчдын 2 жилийн хугацааны АНУ-д суралцах нийт зардал нь дунджаар 100.000-125.000 ам доллартай тэнцэх хэмжээтэйгээр төсөвт суудаг байна. Хэрэв АНУ-ын засгийн газраас олгодог Фулбрайтын тэтгэлгийг нэг жилд дунджаар 4-5 хүнд олгодог гэж үзвэл АНУ-ын засгийн газар Монголын боловсролын салбарыг хөгжүүлэхэд ойролцоогоор 500-625.000 мянган ам долларыг зарцуулдаг гэсэн тооцоо гарч байна. Суралцагчид магистрын зэргээ хамгаалсныхаа дараа эх орондоо заавал эргэн ирж 2-3 жилийн хугацаанд ажиллаж өөрийн сурсан мэдсэнээ салбарынхаа хөгжилд хувь нэмрээ оруулах шаардлага тавигддаг байна. Харин яг ямар хувь нэмрийг хэрхэн, ямар байдлаар оруулдаг нь тодорхой бус байгаа юм.

Харин Монгол засгийн газраас санхүүжүүлдэг Фулбрайтын тэтгэлгийг нэг жилд дунджаар 10-12 хүнд олгодог гэж үзвэл МУ-ын засгийн газар өөрийн боловсон хүчнийг бэлтгэхэд буюу боловсролын салбарыг хөгжүүлэхэд ойролцоогоор 1-12.000.000 сая ам долларыг

зарцуулдаг гэсэн тооцоо гарч байна. 2016 оны 12 сарын байдлаар Монголын засгийн газраас санхүүжүүлдэг Фулбрайтын тэтгэлгийг зэргийн бус судалгааны чиглэлийн горилогчдод олгоогүйгээс үзэхэд Монгол улсын засгийн газрын тэтгэлэг магистрын зэрэг горилсон суралцагчдад илүү их боломжийг олгохоос гадна 2008 оны 83 тогтоолоор батлагдсан МУ-ын засгийн газраас стратегийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарууд болох хөдөө аж ахуй, аж үйлдвэр, боловсрол, шинжлэх ухаан, аялал жуулчлал, уул уурхай, экологи, хүрээлэн буй орчин, хөнгөн үйлдвэрийн салбарт ирээдүйд ажиллах боловсон хүчнийг сэлбэх зорилготойгоор бэлтгэсэнийг харж болохоор байна.

1994-2016 оны хооронд судалгаа хийх зорилготой зэргийн бус сургалтанд хамрагдсан нийт 4 хүн байгаагаас бүгд АНУ-ын Засгийн газраас олгодог Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт 1 хүртэлх жилийн хугацаатай хамрагдсан байна. Судалгааны чиглэлийн хувьд америк судлал (1994-1995), макро эдийн засаг (1999-2000), боловсрол (2000-2001) гэсэн салбарууд зонхилж байна.

Хүснэгт.3 Зэргийн болон зэргийн бус сургалтын үзүүлэлт.




Таблиц 1. АНУ-ын болон Монголын засгийн газрын санхүүжилтээр Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсадын талаарх бичил судалгаа.

Дд	Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан огноо	Засгийн газрын ангилал	Тэтгэлэгийн төлөв	Зэргийн болон зэргийн бус төлөв	Зэргийн ангилал
1	1994-1995	1	АНУЗГ	Судалгаа	Зэргийн бус	
2	1995-1995	1	АНУЗГ	Судалгаа	Зэргийн бус	
3	1995-1996	2	АНУЗГ	Сургалт	Магистр	
4	1997-1999	3	АНУЗГ	Сургалт	Магистр	
5	1998-2001	1	АНУЗГ	Сургалт\ Судалгаа	Доктор	
6	1999-2000	1	АНУЗГ	Судалгаа	Зэргийн бус	
7	1999-2001	3	АНУЗГ	Сургалт	Магистр	
8	2000-2001	1	АНУЗГ	Судалгаа	Зэргийн бус	
9	2000-2002	2	АНУЗГ	Сургалт	Магистр	
10	2001-2003	3	АНУЗГ	Сургалт	Магистр	
11	2002-2003	1	АНУЗГ	Сургалт	Магистр	
12	2002-2004	2	АНУЗГ	Сургалт	Магистр	
13	2003-2004	1	АНУЗГ	Сургалт	Магистр	
14	2003-2005	1	АНУЗГ	Сургалт	Магистр	
15	2004-2005	1	АНУЗГ	Сургалт	Магистр	
16	2004-2006	2	АНУЗГ	Сургалт	Магистр	
17	2005-2006	1	АНУЗГ	Сургалт	Магистр	
18	2005-2007	1	АНУЗГ	Сургалт	Магистр	
19	2006-2007	1	АНУЗГ	Сургалт	Магистр	
20	2006-2008	3	АНУЗГ	Сургалт	Магистр	
21	2007-2008	1	АНУЗГ	Сургалт	Магистр	

PAX MONGOLICA

22	2007-2009	3	АНУЗГ	Сургалт	Магистр		
23	2008-2010	3	АНУЗГ	Сургалт	Магистр		
24	2008-2011	1	АНУЗГ	Сургалт\ Судалгаа	Доктор		
25	2009-2011	2	АНУЗГ	Сургалт	Магистр		
26	2009-2012	1	АНУЗГ	Сургалт\ Судалгаа	Доктор		
27	2010-2013	1	АНУЗГ	Сургалт\ Судалгаа	Доктор		
28	2010-2012	4	АНУЗГ	Сургалт	Магистр		
29	2011-2013	12	МУЗГ	Сургалт	Магистр		
		4	АНУЗГ	Сургалт	Магистр		
30	2012-2014	12	МУЗГ	Сургалт	Магистр		
		4	АНУЗГ	Сургалт	Магистр		
		1	АНУЗГ	Сургалт\ Судалгаа	Доктор		
31	2013-2014	2	АНУЗГ	Сургалт	Магистр		
32	2013-2015	4	АНУЗГ	Сургалт	Магистр		
		9	МУЗГ	Сургалт	Магистр		
33	2014-2016	5	АНУЗГ	Сургалт	Магистр		
		9	МУЗГ	Сургалт	Магистр		
34	2015-2017	9	МУЗГ	Сургалт	Магистр		
		4	АНУЗГ	Сургалт	Магистр		
35	2016-2018	11	МУЗГ	Сургалт	Магистр		
		6	АНУЗГ	Сургалт	Магистр		
	1994-2016		АНУЗГ (78)	МУЗГ (62)	Сургалт-131 Судалгаа-4 Сургалт\ Судалгаа-5	Магистр-131 Зэргийн бус-4 Доктор-5	
	Нийт	140	140	140	140		

Хүснэгт.4 1994-2016 онд Фулбрайтын хөтөлбөрт ямар салбараас хамрагдсан талаарх тоон үзүүлэлт.



Таблиц.2 Салбар тус бүрээр

Дд	Салбар тус бүрээр	Хамрагдсан хүний тоо	Сургуулиудын нэршил
1	Эдийн Засаг, Олон Улсын Эдийн Засаг	13	
2	Мэдээллийн Технологи	9	
3	Олон Улсын Харилцаа ба Олон Улсын хөгжил	6	
4	Улс төрийн шинжлэх ухаан	3	
5	Бизнесийн удирдлага MBA	5	
6	Нийгмийн ажил	3	
7	Боловсрол судлал	3	
8	Соёлын антропологи	2	
9	Геологи, уул уурхай	3	
10	Эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч	3	
11	Нийтийн Эрүүл Мэнд	8	
12	Америк судлал	3	
13	Экологи, хүрээлэн буй орчны асуудлууд	5	
14	Нийтийн Удирдлага	5	
15	Соёл Урлаг	4	
16	Дуу хөгжим	1	
17	Сэтгэл судлал	2	
18	TESOL	2	
19	Хүний нөөц	2	
20	Байгалийн баялагийн менежмент	1	
21	Агаарын тээвэр	1	

22	Биологи ба инженерчлэл	5	
23	Хот төлөвлөлт	2	
24	ОУ-ын Бизнес ба Худалдааны Эрх Зүй	1	
25	Дипломат Ажиллагаа ба Эрх зүй	1	
26	Сэтгүүл зүй	1	
27	Номын сангийн шинжлэх ухаан	2	
28	Олон улсын бодлогын судалгаа	1	
29	Иргэншил	1	
30	Уул уурхайн эдийн засаг	1	
31	Хэл шинжлэл	1	
32	бусад	40	

2. Хамфрейн тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх судалгаа

Хоёр орны ард түмэн хоорондын өнө удаан жилийн нөхөрсөг харилцааг бий болгоход зөөлөн хүчний гол үүрэг оршино. Өмнө дурдсанчилан, энэхүү хүчийг хэрэгжүүлэхэд олон нийтийн дипломат ажиллагааны үүрэг өндөр бөгөөд түүний үндсэн элементүүд дундаас соёл, боловсролын солилцоо болон урт, богино хугацааны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрүүд голлох үүргийг гүйцэтгэнэ. Соёл, боловсролын хөтөлбөрөөр дамжуулж нэг улс өөрийн улсын талаарх эерэг имидж, төсөөллийг нөгөө улс үндэстэнд бий болгож, ард түмэн хоорондын урт удаан хугацааны нөхөрсөг харилцаа, бүрэн ойлголцлийн үндсийг тавьдаг хэмээн өмнө дурдсан билээ.

Аливаа хоёр орны харилцаа иргэд хоорондын харилцаан дээр суурилах аваас “энэ нь улс орнуудын хамтын нөхөрлөлийн гол үндэс суурь төдийгүй бусад чиглэлийн урт удаан хугацааны харилцааг бий болгох эхлэл болдог”³⁵ хэмээн 2009-2012 онд АНУ-аас Монгол улсад суусан Онц Бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд ноён Жонатан Эдлтон өөрийн бүтээлдээ дурдсан байдаг. Монгол, АНУ-ын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтохоос бүр өмнө америк, монгол хүмүүс хоорондоо уулзаж, санаандгүй

35 Жонатан Эдлтон, “Нэгэн Чухал Хүчин Зүйл: АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа, 1987-2012”, УБ хот, 2012, 125 тал

байдлаар учирч байв. 1920-оод онд Монголын их говиор аялсан Рой Чапмен Эндрюсын шинжилгээний ангийн аялалын үеэр авсан гэрэл зургууд харилцааны эхэн үеийн зарим түүхийг мөн гэрчилнэ.³⁶

Фулбрайтын хөтөлбөрөөс гаднаас өөр хэд хэдэн бий. АНУ-ын элчин сайдын яамны зүгээс АНУ-д суралцах хүсэлтэй монголчуудын суралцах боломжийг дэмжих үүднээс дараагийн нэг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тэр бол АНУ-ын хуучин Дэд Ерөнхийлөгч, Сенатор Хюберт Хамфрейн нэрээр нэрлэгдсэн Хюберт Хамфрейн тэтгэлэгт хөтөлбөрт 2011 оны байдлаар 24 хүн хамрагдсан бол 2016 оны байдлаар 34 хүн болж нэмэгдсэн байдаг. Тус хөтөлбөр нь салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж буй дундаж насны судлаач мэргэжилтнүүдийн мэргэжил боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаардаг. Хамфрей тэтгэлэг хүртсэн монголчууд АНУ-ын Корнелийн их сургуульд байгалийн нөөцийн менежмент, Вандербильтийн их сургуульд боловсролын удирдлага гээд мэргэжлийн бүхий л чиглэлээр суралцсан.³⁷

АНУ-ын Төрийн Департамент болон Улаанбаатар дахь АНУ-ын элчин сайдын яамны Соёл, Боловсролын Асуудал Хариуцсан Товчоо болон Олон Нийтгэй Харилцах Албанаас 1996 оноос эхлэн Монгол улсад хэрэгжүүлж буй хоёрдахь том хөтөлбөр бол Хамфрейн тэтгэлэгт хөтөлбөр юм. Анх 1995 оноос бэлтгэлээ хангаж ирэх жилээс нь амжилттай хэрэгжиж эхэлсэн энэхүү хөтөлбөрт 1996-2016 оны байдлаар нийтдээ 34 гаруй хүн хамрагдаад байна. Хамфрейн хөтөлбөр нь Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрийг бодвол харьцангуй богино хугацааны, зэргийн бус хөтөлбөр бөгөөд уг тэтгэлэгт хамрагдахаар материалаа өгсөн нэр дэвшигчдийн дунд өрсөлдөөн харьцангуй их, шат дараатай явагддаг. Учир нь нэр дэвшигчид эхлээд өөрийн салбарынхаа дотоодын нэр дэвшигчидтэй өрсөлдөж, дараа нь бүс нутгийн орнуудаас шалгарсан бусад нэр дэвшигчидтэй халз өрсөлдөж, тухайн жилийн Хамфрийн тэтгэлэгт хөтөлбөрийн хорооны гишүүдтэй онлайнгаар шууд ярилцлаганд орно. Шалгарсан тохиолдолд нэр дэвшигч АНУ-ын их, дээд сургуулиудад өөрийн тухалсан чиглэлээр ямар судалгааг хийх, судалгааны ажлын зорилго юу байх, ямар үр дүн гарах, тус хөтөлбөрт хамрагдсанаараа салбарын хөгжилд өөрийн зүгээс оруулах бодит хувь нэмэр юу байх зэрэг дээр үндэслэн тухайн жилд тэтгэлэг хүртэх нэр дэвшигчдийг тодруулдаг байна. Жил бүр хэдэн


36 мөн тэнд.

37 Жонатан Эдлтон, “Нэгэн Чухал Хүчин Зүйл: АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа, 1987-2012”, УБ хот, 2012, 133 тал

Монгол улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ой

хүнийг АНУ-ын засгийн газраас явуулах нь тухайн жилийн санхүүгийн

Схем 1. Салбар бүрийн ангилал.



Дүгнэлт

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ой 2017 онд тохиож, хоёр улс ойг хамтран тэмдэглэнэ. Америкийн Нэгдсэн Улс нь Монгол Улсын гуравдагч хөрш, чухал түнш, томоохон хөрөнгө оруулагч юм. Манай хоёр улсын хооронд улс төр, батлан хамгаалах, эдийн засгийн хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж, ялангуяа хоёр орны ард түмэн хоорондын нягт, дотно харилцаа гүнзгийрч, батжиж байна.

Энэ жил мөн Энхтайвны корпусын анхны сайн дурын ажилтнууд Монголд ирж ажилласны 25 жилийн ой мөн тохиож байгаа төдийгүй өнгөрсөн хугацаанд 1200 шахам сайн дурынхан манай орны хот, хөдөөд ажилласан. Мөн энэ жил дэлхийд алдартай АНУ-ын Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрийн 70 жилийн ой болсон. Монголын 350 гаруй залуус энэхүү хөтөлбөрийн хүрээнд АНУ-д боловсрол эзэмшсэн. Хэдхэн хоногийн өмнө АНУ-ын Засгийн газар Монгол Улсыг Мянганы сорилтын корпорацийн хоёр дахь компакт гэрээ байгуулах орноор дахин шалгаруулсан билээ.

Саяхан талууд улс төрийн ээлжит зөвлөлдөх уулзалтаа амжилттай хийж, түүгээр цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар дэлгэрэнгүй ярилцаж, тохиролцсон.

Ийнхүү Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөжиж, идэвхтэй хөгжиж байгаа бөгөөд хоёр тал 2017 онд эдгээр амжилтаа бататгаж, харилцааны цаашдын зорилгоо тодорхойлж, 30 жилийн ойгоо хамтран өргөнөөр тэмдэглэн өнгөрүүлж байна.

Үүнээс үзэхэд МУ-АНУ-ын хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа боловсролын салбарт нилээн эрчимтэй хөгжиж байгаа нь дээрх үзүүлэлтээс тодорхой харагдаж байгаа төдийгүй МУ-ын боловсролын салбарт АНУ-ын засгийн газраас үзүүлж буй хөрөнгө оруулалт нилээн өндөр хувийг эзэлж байна. Учир нь АНУ-ын засгийн газраас хэрэгжүүлдэг Фулбрайтын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 123 оюутны 71 нь хамрагдсанаас үзэхэд АНУ-ын засгийн газар оюутан тутамд 100-125.000 ам долларыг магистрын зэргийн 2 жилийн сургалтын хугацаанд олгодог гэсэн албан бус тооцоо байдаг. Үүнийг тооцож үзэхэд 7.100.000-8.875.000 ам долларын хөрөнгө оруулалтыг Монгол улсын залуучуудыг сургах үйлсэд хөрөнгө оруулсан гэсэн үг юм. Аливаа нэг улс нөгөө улсын соёл, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжих бодлогыг олон улсын харилцаанд зөөлөн хүчний бодлого буюу тэр дундаа олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлж байна үздэг. Зарим эрдэмтэн судлаачид олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгжүүлэх хямд төсөр, эрсдэл багатай хамтын ажиллагааны хэлбэр ч дүгнэдэг. Гэтэл дээрх дүнгээс харахад АНУ-ын засгийн газар Монгол улсын боловсролын салбарыг дэмжиж 9 сая ам долларын зарцуулсан явдал нь зөвхөн өөрийн улсын имидж, төрхийг Монгол улсад сайжруулахын тулд хөрөнгө гэж үзвэл дэндүү их өндөр өртөгтэй имидж бүрдүүлэлт гэж дүгнэхээр байна. Монгол улсын засгийн газар 2008 онд стратегийн ач холбогдол бүхий тэргүүлэх салбаруудын тоонд уул уурхай, аж үйлдвэр, эрүүл мэнд, аялал жуулчлал, эрчим хүч, соёл, боловсролын салбарыг зүй ёсоор оруулсан байдаг. Энэхүү боловсролын салбарын хамтын ажиллагааны хэлбэр нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт дэмжин ажиллах гол тулгуур гэж үзэж болохоор байна. Учир нь АНУ-д магистрын зэргийн эзэмшиж ирсэн мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэг чадвар өндөр оюутан залуус мэргэжил эзэмшсэн өөр өөрийн бүхий л салбарт ажиллаж өөрсдийн эзэмшсэн мэдлэгийг тухайн салбарыг хөгжүүлэх үйлсэд бүрнээ зориулах болно гэдэгт итгэлтэй байна.

Ашигласан бүтээлүүд

Монгол эх сурвалж

1. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. “Дипломат Ажиллагаа, Дипломат Албаны Үндэс”, УБ, 1998 он
2. Жонатан Эдлтон. “Нэгэн Чухал Хүчин Зүйл: АНУ-Монгол Улсын Дипломат Харилцаа, 1987-2012”, УБ, 2012 он
3. МУ-ын Гадаад Бодлогын “Хөх Ном”, Гадаад Хэргийн Яам, УБ, 2012 он
4. Б.Хонгорзул. “Гадаадад Магистарт Хэрхэн Суралцах Вэ”, УБ, 2016 он
5. Д.Цолмон, Д.Оюунсүрэн, С.Баясгалан. “Гадаад бодлого, дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс”, УБ, 2009 он
6. МУ-ын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал, УБ, 2011 он
7. Д.Цолмон, Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг, УБ, 2003 он
8. Г.Төмөрчулуун. “Олон Улсын Харилцааны онолуудын ерөнхий тойм” УБ, 2014 он

Англи эх сурвалж

1. Joseph S.Nye. Jr. “The Paradox of American Power: Why the World’s Only Super Power Can’t Go it Alone”, 1st edition of Public Affairs, USA, 2002
2. Joseph S.Nye. Jr. “Soft Power: The Means to Success in World Politics”, 1st edition of Public Affairs, USA, 2004
3. Joseph S.Nye. Jr. “The Future of Power”, 1st edition of Public Affairs, USA, 2011
4. Jan Mellisan, “The New Public Diplomacy: Soft Power in International Relations”, UK, 2012
5. Sook Jong Lee and Jan Mellisan, “Public Diplomacy and Soft Power in East Asia”, UK, 2012
6. Media Note of Office of the Spokesperson, U.S. Department of State Public Diplomacy Programs for Mongolia, Washington DC, June 17, 2011

7. Japanese Diplomatic Bluebook, 2005, /Topic: Soft Power/, p.p.208
8. Dr. Robert Taylor, The British Council, Cultural Diplomacy-The Future
9. Committee on Cultural Diplomacy in U.S. Department of State, “The Cultural Diplomacy is linchpin of Public Diplomacy” report, Sep 2005
9. Margaret Wyszomirski, Christopher Burgess and Catherine Peila, International Cultural Relations: A Multi Country Comparison, 2003
10. http://www.azer.com/aiweb/categories/magazine/84_folder/84_articles/84_guinhut.html

Ярилцлага буюу интервью (structured type) хийсэн огноо.

1. Б.Хонгорзул. (School of Law and Diplomacy, Tufts University) Interview/2016.03.30
2. Х. Нинж-Эрдэнэ. (State University of Albany) Interview/2016.06.10
3. Э.Ариунаа (Syracuse University) Interview/ 2016.08.23
4. С. Мөнхзул. (Ohio University) Interview/2016.10.23
5. Э.Билгүүн. (Univesity of Cornell) Interview/ 2016.11.08

* * *

Д. Бүдсүрэнгийн товч намтар.

МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн багш, доктарант

МУИС-ийн ОУХДС-ийг гадаад албаны ажилтан, Англи-Америк орон судлал мэргэжлээр бакалаврын, МУИС-ийн ОУХС-д “Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын асуудал: Монгол улсын оролцоо” сэдвээр Олон улсын харилцааны магистрын зэрэг хамгаалсан.

2005 оноос МУИС-ийн ОУХС-ийн олон улсын харилцааны докторантурт суралцаж, “Монгол-Америкийн харилцаанд нийтийн дипломат ажиллагааны гүйцэтгэх үүрэг: Фулбрайт болон Хамфрейн солилцооны хөтөлбөрийн жишээн дээр” сэдвээр судалгааны ажил хийж буй.

Монгол-Америкийн боловсролын салбарын хамтын ажиллагаа, АНУ-ын гадаад бодлого, нийтийн дипломат ажиллагаа, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого зэрэг чиглэлээр 20 эрдэм шинжилгээний өгүүллийг англи, монгол хэлээр бичиж хэвлүүлсэн. Их Британийн Сэнт Эндрюсын Их сургууль дээр “Туравдагч хөршийн асуудал Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чухал хүчин зүйл болох нь” сэдвээрх докторын судалгааны ажлаа тус сургуулийн Профессор Rick Fawn-ны удирдлага дор хийж гүйцэтгэсэн.